

“ХҮН БОЛОХ БАГААСАА” ГАДААД ХЭЛНИЙ ТӨСЛИЙН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

Ерөнхий мэдээлэл:

“Хүн болох багаасаа” гадаад хэлний сургалтын төсөл нь Дорнод аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 13/18 дугаар тогтоолоор батлагдсан.

“Хүн болох багаасаа” гадаад хэлний сургалтын төслийн зорилго нь Дорнод аймгийн хүүхдүүдийн гадаад хэлний мэдлэг чадварыг хөгжүүлж, сурах арга барил эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэн, зөв хүмүүжилтэй, бүтээлч иргэдийг төлөвшүүлэх.

Хамрах хүрээ:	Сургалтанд аймгийн төв болон хөдөөгийн 13 сумын ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн нийт 2278 суралцагчийн гадаад хэлний мэдлэг чадварыг хөгжүүлэх сургалт, дугуйланд хамруулна.
Сургалт зохион байгуулах хугацаа:	Сургалт хоёр хичээлийн жил дамжин үргэлжлэх бөгөөд 2023-2024 оны хичээлийн жилийн III улирлаас 2024-2025 оны хичээлийн жилийн II улирал дуустал үргэлжилнэ.
Сургалтын нэр төрөл:	1. Орос хэлний сургалт 2. Хятад хэлний сургалт 3. Англи хэлний сургалт 4. Япон хэлний сургалт 5. Солонгос хэлний сургалт <i>/Тендэрт оролцогч нь төслийн багц, төрлийг сонгон материалаа ирүүлнэ/</i>
Захиалагч нь:	1. Сургалт зохион байгуулах байрны зохих дэмжлэг үзүүлнэ. 2. Сургалтад хамрагдаж байгаа хүүхдүүдийн гадаад хэлний мэдлэгийн түвшинд хөндлөнгийн үнэлгээ хийнэ.

Сургалт зохион байгуулах ерөнхий шаардлага:

1.	Сургалтыг хүүхдүүдийн нас, сэтгэхүй, гадаад хэлний мэдлэгийн түвшинд нь тохирсон хөтөлбөрөөр чанартай зохион байгуулна. Сургалтын хөтөлбөрийг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар батална.
2.	Суралцагчдыг гадаад хэлний зохих түвшний мэдлэг боловсролтой, багаар ажиллах чадвартай, зөв хүмүүжилтэй иргэн болж төлөвшүүлэхэд чиглэсэн сургалтын бүтээлч аргуудыг ашиглан зохион байгуулна.
3.	Төслийн Хувь хүний хөгжлийн сургалтын багцыг гүйцэтгэхээр захиалагчтай гэрээ байгуулсан хуулийн этгээдтэй хамтран ажиллана.
4.	Бусад ижил төрлийн дугуйлан, клуб, сургалтын төв, сургуулиудтай хамтарсан нөхөрсөг уралдаан, тэмцээн, сургалт, уулзалтыг зохион байгуулж, аймаг, бүс, улс, олон улсын уралдаан, тэмцээнд хүүхдүүдийг оролцуулна.
5.	Сургалтад аймгийн төв болон хөдөөгийн сумдын хүүхдүүдийг тэгш хүртээмжтэй хамруулна. /тухайн сумын ЕБС-ийн мэргэжлийн багш нартай хамтран ажиллана/

6.	Орон нутгийн төсвөөс олгох санхүүжилтийг сургалтад хамруулах хүүхдийн тоогоор тооцож олгоно. Иймд тендэрт оролцогч сургалтад хамруулах хүүхдийн тоог нарийвчлан тооцож, төсвийн задаргааг дэлгэрэнгүй боловсруулна. /нэг хүүхдийн сургалтын хувьсах зардал 30,000 төгрөг буюу 1 хүүхдийг сургах 1 цагийн хувьсах зардал 1,500 төгрөг/
7.	Суралцагч хүүхдүүдийн амжилтын түүхийг эцэг, эх, асран халамжлагч, ангийн багш, сургуульд нь хуваалцаж, байнгын эргэх холбоотой хамтран ажиллана.
8.	Хүүхэд нэг бүрийн ур чадварын түвшинг тогтоох үнэлгээг сургалтын эхэнд, дунд, төгсгөлд хийнэ. Түвшин тогтоох үнэлгээ хийхэд тухайн чиглэлийн байгууллага, мэргэжилтэний төлөөллийг оролцуулна.
9.	Сургалтын үйл ажиллагаа, хүүхдүүдийн бүтээл, авьяас, амжилтын түүхийг олон нийт, хэвлэл, мэдээлэл, цахим хуудсаар тогтмол мэдээлж, тайлагнана.

Сургалтын тендэрт оролцогчдод тавигдах шаардлага:

1.	Тендэрт оролцох албан хүсэлт, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
2.	Байгууллагын танилцуулга: Үйл ажиллагааны чиглэл
3.	Ажлын туршлага: Сургалт зохион байгуулж байсан туршлага, амжилтын түүх, хамтран ажилласан байгууллагын мэдээлэл
4.	Хүний нөөцийн мэдээлэл: Тухайн чиглэлийн багш мэргэжлийн бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй эсхүл эрх бүхий байгууллагаас олгосон тухайн чиглэлээр сургалт зохион байгуулах эрхтэй байх /танилцуулга, холбогдох баримт бичгийг хавсаргах/
5.	Сургалт явуулах орчин, нөхцөл: Сургалтын хөтөлбөр, сургалт явуулах анги танхим, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл
6.	Тендэрт оролцогч нь олон улсын байгууллага, ижил төстэй үйл ажиллагаа явуулж байгаа төсөл, хөтөлбөртэй хамтран ажиллах бол давуу тал болно. /Хамтран ажиллах гэрээний хуулбар/
7.	<p>Сургалтын төсөв: “Хүн болох багаасаа” гадаад хэлний сургалтын төсөл нь аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжинэ.</p> <ul style="list-style-type: none"> - Төслийн санхүүжилтийг: Сургалт явуулах анги танхимын урсгал зардал, сургалтын хэрэглэгдэхүүн, багшийн урамшуулалд төлөвлөх - Санхүүжилтийг гадаад хэлний төслийн сургалтад хамруулах хүүхдийн тоо, сургалтын цагийн сар тутмын гүйцэтгэлээр тооцож олгоно. - Төслийн сургалтад хамрагдаж байгаа хүүхдүүдээс нэмэлт төлбөр авч болно. Нэг хүүхдээс авах сургалтын төлбөр 20,000 төгрөгөөс хэтрэхгүй. - Бусад эх үүсвэр <p>Зөвшөөрөгдөхгүй зардал: хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагаанд оролцоогүй хүнд цалин урамшуулал олгох, тавилга тоног төхөөрөмж, үл хөдлөх хөрөнгө, хувьцаа, үнэт цаас худалдан авах</p>

ХЯНАСАН
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН
БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Э.ЭРДЭНЭБИЛЭГ

БОЛОВСРУУЛСАН
АЙМГИЙН БОЛОВСРОЛ, ШИЖЛЭХ УХААНЫ ГАЗРЫН
ДАРГА Ч.АРИУНАА



БАТЛАВ: АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

М.БАДАМСҮРЭН.



ХҮН БОЛОХ БАГААСАА-ГАДААД ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ТӨСЛИЙН 2024 ОНЫ СУРГАЛТЫН БАГЦ, ТӨСВИЙН ЗАДАРГАА

Аймгийн ИТХ --ын 2023 оны 12-р сарын 04-ний өдрийн 19/11 дүгээр тогтоол. "2024 оны төсөв батлах тухай" ОНХС-ын 2.13 дахь заалт. "Хүн болох багаасаа" гадаад хэлний сургалтын төслийг үргэлжлүүлэх

Багц	Сумд болон аймгийн сургуулийн нэрс	Сургуулийн бага ангийн сурагчдын тоо	Төсөлд хамрагдах хүүхдийн тоо	төсөл хэрэгжих хугацаанд хичээллэх цаг			Багцын санхүүжилт, төг / 1 хүүхэд, 1 цагт 1,500 төг/		
				сургалтын нийт, цаг	үүнээс: гадаад хэл /1 сард 20 цаг*6 сар/	Хувь хүний хөгжил /1 сард 4 цаг*6 сар/	нийт төсөв	үүнээс: гадаад хэл	Үүнээс: Хувь хүний хөгжил
1	Баяндун	267	64	144	120	24	13,824,000	11,520,000	2,304,000
2	Баянтүмэн	83	22	144	120	24	4,752,000	3,960,000	792,000
3	Баян-Уул	504	116	144	120	24	25,056,000	20,880,000	4,176,000
4	Булган	117	28	144	120	24	6,048,000	5,040,000	1,008,000
5	Гурванзагал	94	23	144	120	24	4,968,000	4,140,000	828,000
6	Дашбалбар	303	70	144	120	24	15,120,000	12,600,000	2,520,000
7	Матад	199	47	144	120	24	10,152,000	8,460,000	1,692,000
8	Сэргэлэн	125	30	144	120	24	6,480,000	5,400,000	1,080,000
9	Халхгол	277	70	144	120	24	15,120,000	12,600,000	2,520,000
10	Хөлөнбуйр	208	49	144	120	24	10,584,000	8,820,000	1,764,000
11	Цагаан-Овоо	363	84	144	120	24	18,144,000	15,120,000	3,024,000
12	Чойбалсан	168	40	144	120	24	8,640,000	7,200,000	1,440,000
13	Чулуунхороот	177	42	144	120	24	9,072,000	7,560,000	1,512,000
14	Хэрлэн сумын 1 дүгээр сургууль	1210	275	144	120	24	59,400,000	49,500,000	9,900,000
15	Хэрлэн сумын 5 дугаар сургууль	1050	239	144	120	24	51,624,000	43,020,000	8,604,000
16	Хэрлэн сумын 12 дугаар сургууль	824	188	144	120	24	40,608,000	33,840,000	6,768,000
17	Хэрлэн сумын Фловёр, Түгээмэл Оюун сургууль	132	32	144	120	24	6,912,000	5,760,000	1,152,000
18	Хэрлэн сумын 2 дугаар сургууль	198	47	144	120	24	10,152,000	8,460,000	1,692,000
19	Хэрлэн сумын 11 дүгээр сургууль	265	62	144	120	24	13,392,000	11,160,000	2,232,000
20	Хэрлэн сумын Шинэ Хөгжил цогцолбор сургууль	1119	254	144	120	24	54,864,000	45,720,000	9,144,000
21	Хэрлэн сумын 8 дугаар сургууль	1133	257	144	120	24	55,512,000	46,260,000	9,252,000
22	Хэрлэн сумын Долоодой сургууль	136	33	144	120	24	7,128,000	5,940,000	1,188,000
23	Хэрлэн сумын Хан-Уул цогцолбор сургууль	903	206	144	120	24	44,496,000	37,080,000	7,416,000
	Бүгд	9855	2278				492,048,000	410,040,000	82,008,000

2024 оны төлөвлөлт

төсөлд хамрагдах хүүхэд

2278

Сургалтын нийт батлагдсан төсөв

540,000,000

Үүнээс: Сургалтын төсөв

492,048,000

Теле, цахим хичээл

15,000,000

Уралдаан, тэмцээн

17,612,000

Захиалагчын хяналт, Байнгын ажлын хэсэг

15,340,000

бүгд, төгрөг

540,000,000

Хянасан:

Э.Эрдэнэбилэг. Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Бэлтгэсэн:

Ч.Ариунаа. Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга

Ө.Болорчимэг. Аймгийн БШУГ-ын арга зүйч